

## МОНГОЛ-GERМАНЫ ХАМТАРСАН АШИГТ МАЛТМАЛ, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРИЙН СУРГАЛТЫН БОЛОН ШАЛГАЛТЫН ЖУРАМ

Монгол Улсын Дээд боловсролын тухай хууль болон Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль ("МГТИС")-ийн Дүрмийг үндэслэн МГТИС-ийн Эрдмийн Зөвлөлөөс 2017 оны 3-р сарын 28-нд дараах Бакалаврын зэрэг олгох хөтөлбөрийн сургалтын болон шалгалтын журмыг батлав.

### Оршил

Сургалтын болон шалгалтын журмаар МГТИС-ийн Инженерийн факультет, Математик, компьютер, байгалийн шинжлэх ухааны факультетаас санал болгодог Хүрээлэн буй орчны инженер, Механик инженер, Уул уурхайн боловсруулах инженер, Үйлдвэрлэлийн эдийн засагч инженерийн Бакалаврын зэрэг олгох хөтөлбөрүүдийн зорилго, агуулга, бүтэц, шалгалтын журмыг тодорхойлов.

### Гарчиг

Хэсэг А – Сургалтын журам .....	4
§1. Хөтөлбөрийн зорилго, зорилт .....	4
§2. Боловсролын зэрэг .....	4
§3. Хөтөлбөрийн үргэлжлэх хугацаа, бүтэц .....	4
§4. Хичээл заах хэл .....	5
§5. Элсэлт ба мэргэжил сонголт .....	5
§6. Хичээл, хичээлийн тодорхойлолт .....	5
§7. Үндсэн хичээл, сонгон суралцах хичээл .....	6
§8. Багц цаг, суралцагчийн ачаалал ба хичээлийн цаг .....	7
§9. Гүйцэтгэл ба хичээлийн үнэлгээ .....	7
§10. Хөтөлбөрийн зохицуулагч .....	8
Хэсэг В – Шалгалтын журам .....	8
I. Шалгалтын тодорхойлолт .....	8
§1. Бакалаврын хөтөлбөрийн шалгалтын зорилго .....	8
§2. Хичээлийн шалгалт .....	9
§3. Шалгалтын агуулга, төрөл .....	9
§4. Бичгийн шалгалт .....	10

§5. Аман шалгалт .....	10
§6 Өөр хэлбэрийн шалгалт .....	10
II. Шалгалтыг зохион байгуулах .....	11
§7. Шалгалтын комисс .....	11
§8. Шалгагч, зөвлөх, хянагч багш .....	12
III. Шалгалтын хугацаа, шаардлага, бүртгэл, шалгалтад орохгүй байх .....	13
§9. Шалгалтын хугацаа .....	13
§10. Шалгалтад ороход тавих шаардлага .....	13
§11. Суралцсан хугацаа, шалгалтыг тооцох .....	14
§12. Бүртгэл .....	15
§13. Шалгалт өгөхгүй байх, сүүлийн хугацаа .....	16
IV. Бакалаврын дипломын ажил .....	16
§14. Нэр томъёоны тодорхойлолт .....	16
§15. Дипломны ажлын сэдэв авахад тавих шаардлага, даалгавар, дипломны ажлыг хүргүүлэх .....	17
§16. Дипломны удирдагч ба үнэлгээ .....	18
V. Шалгалтын үнэлгээ .....	19
§17. Дүнгийн тодорхойлолт .....	19
§18. Дүн .....	19
VI. Дахин шалгалт, Бакалаврын шалгалтад амжилтгүй дүн үзүүлэх .....	21
§19. Дахин шалгалт .....	21
§20. Бакалаврын шалгалтад амжилтгүй дүн үзүүлэх .....	21
§21. Шалгалтын материалтай танилцах .....	22
§22. Санал, номдол шийдвэрлэх .....	22
VII. Гэрчилгээ .....	22
§23. Диплом .....	22
§24. Бакалаврын зэргийн диплом .....	23
§25. Дипломын дагалдах хавсралт .....	23
§26. Дипломын дүнгийн хавсралт .....	23
VIII. Шалгалтын журмыг зөрчих .....	23
§27. Шалгалтанд хууль бусаар орох .....	23
§28. Шалгалтын үеэр хуулах, дүрэм зөрчих .....	24
IX. Хүчин төгөлдөр болох .....	24
Хэсэг С - Хавсралтууд .....	25
Хавсралт 1 – Хичээлийн гарын авлага Уул уурхайн боловсруулах инженер .....	25
Хавсралт 2 – Хичээлийн гарын авлага Хүрээлэн буй орчны инженер .....	25
Хавсралт 3 – Хичээлийн гарын авлага Механик инженерийн .....	25
Хавсралт 4 – Хичээлийн гарын авлага Үйлдвэрлэлийн эдийн засагч инженер .....	25

## **Хэсэг А – Сургалтын журам**

### **§1. Хөтөлбөрийн зорилго, зорилт**

- (1) Хөтөлбөрийн зорилго нь тухайн инженерчлэлийн салбарт хүссэн ажил хөдөлмөр эрхлэх, хувиараа бизнес эрхлэх болон насан туршдаа суралцах эрмэлзэлтэй төгсөгчдийг бэлтгэхэд оршино.
- (2) Бакалаврын зэргийн инженерийн хөтөлбөрийг үзэж судалсан оюутнууд дараах чадвартай болж төгсөнө. Үүнд:
  - Математик, шинжлэх ухаан, инженерийн зарчмыг инженерийн асуудлыг шийдэхэд ашиглах
  - Асуудлыг цогцоор тодорхойлох, дүн шинжилгээ хийх, асуудлыг шийдэх инженерийн шийдлийг боловсруулах, тэдэнд зориулсан цогц шийдлийг хэрэгжүүлэх
  - Инженерийн хувьд нийгэм болоод байгаль орчны инженерийн ахиц дэвшлийг сайжруулахын тулд зураг төсөл, бүтээн байгуулалт, үйлдвэрлэл, нийлүүлэлт, зөвлөх шинжлэх ухааны арга барилыг үнэлэх, ашиглах
  - Мэдээллийн шинжлэх ухааныг инженерийн асуудлыг шийдвэрлэхэд ашиглах
  - Өргөн хүрээний, салбар хоорондын асуудлыг шийдвэрлэхийн тулд олон улсын багт ажиллах
  - Нийгэм, эдийн засаг, байгаль орчны хүрээнд болон хувьд үүрэг хариуцлагатай байхын тулд инженерийн үйл ажиллагааны үр дагаврыг тодорхойлох.
- (3) Тусгай хөтөлбөрүүдийн зорилго, зорилт түүнчлэн, сургалтын төлөвлөгөөний илүү дэлгэрэнгүй тодорхойлолтыг энэхүү журамд хавсаргасан Хичээлийн гарын авлагад дурдав.

### **§2. Дээд боловсролын зэрэг**

- (1) Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль Бакалаврын зэрэг олгодог.
- (2) Зэргийг бүх хичээлийн шалгалт, бакалаврын дипломын ажил, хамгаалалтыг амжилттай дуусгасны дараа олгодог.
- (3) Дээд боловсрол эзэмшихийн тулд Европын кредит шилжүүлэх, цуглуулах систем ("ЕКШЦС")-н дагуу 240 багц цаг цуглуулсан байна.

### **§3. Хөтөлбөрийн үргэлжлэх хугацаа, бүтэц**

- (1) Бакалаврын хөтөлбөрийн үргэлжлэх хугацаа 8 улирал.
- (2) Нэг хичээлийн жил 2 улиралтай: намар (08.01-01.15) болон хавар (01.16-07.31). Нэг улирал 26 долоо хоногтой. Үүнээс 16 долоо хоногт нь танхимын хичээл орно, 3 долоо хоногт нь

шалгалт авна. Долоон хоногийг бие даан суралцахад зориулна. Улирал эхлэхээс өмнө дахин шалгалтын нэмэлт нэг 7 хоногийг дахин шалгалтанд зарцуулна.

- (3) 6-р улиралд багадаа 14 долоо хоног дадлага хийх хуваарьтай. Дадлагыг МГТИС-ийн Дадлага хийх журмын дагуу зохион байгуулна.
- (4) Бакалаврын дипломын ажлыг 8-р улиралд бичнэ. Дэлгэрэнгүйг Шалгалтын журамд дурдав.
- (5) Бакалаврын зэргээр суралцах дээд хугацаа 8 жил байна.

#### **§4. Хичээл заах хэл**

- (1) Хичээл болон шалгалтын хэл Англи хэл байна.
- (2) Онцгой тохиолдлуудыг хичээлийн тодорхойлолтод дурдав.

#### **§5. Элсэлт ба мэргэжил сонгох**

- (1) Элсэлтийн шаардлага болон журмын дэлгэрэнгүйг МГТИС-ийн элсэлт ба элсэх эрх олгох журамд дурдав.
- (2) Журмын дагуу суралцагчдыг Бакалаврын хөтөлбөрт хичээлийн жилийн намрын улиралд элсүүлнэ.
- (3) Бусад их, дээд сургуулиас шилжин суралцаж байгаа болон солилцооны, давхар зэрэг олгох хөтөлбөрийн суралцагчдыг намар болон хаврын улиралд элсүүлж болно.
- (4) Суралцагсад бакалаврын зэрэг олгох сургалтын эхний улиралд элсэх эрх авмагцаа мэргэжлээ сонгоно. Тухайн үед мэргэжлээ сонгох хүсэлгүй суралцагчдыг 3-р улирал хүртэл "мэдүүлээгүй" гэх статустай элсүүлж болно.

#### **§6. Хичээл, хичээлийн тодорхойлолт**

- (1) Бакалаврын зэрэг олгох хөтөлбөр нь хичээл сургалт байна. Хичээл нь онолын хэсгээс бүрдэх мэдлэг олгох хэсэгтэй байна. Хичээлийн агуулгыг нэг улирал эсвэл нэг хичээлийн жилд багтаан судалбал зохино.
- (2) Хичээлд заах арга зүй, сурах арга барилын өөр өөр хэлбэр орно. Лекцээр онолын мэдлэг олгоно. Хичээлээр танхимын хичээлийн материалыг шинэчлэн, агуулгын талаарх оюутны ойлголтыг гүнзгийрүүлнэ. Үүнд асуудлыг шийдэх даалгавар, танилцуулга, бие даалтын ажил, ерөнхий практик орох ба оюутнуудад бие даасан шинжлэх ухааны судалгаа шинжилгээг танилцуулдаг. Лабораторийн хичээлээр оюутнууд онолын мэдлэгээ ашиглах ба аргачлал, практик дадлагын ур чадвараа сайжруулна. Суралцах, заах арга зүйн бусад төрлүүдэд экскурс, сургалтын төслүүд буюу ангийн ажил, дадлага ажил, бие даан суралцах, мөн Бакалаврын дипломын ажил, хамгаалалт орно.
- (3) Журмын дагуу хичээлийг судалж хичээлийн шалгалтаар дуусна. Онцгой тохиолдлуудыг Хичээлийн тодорхойлолтод дурдав.
- (4) Хичээл бүрийг Хичээлийн тодорхойлолтод дэлгэрэнгүй тайлбарлав. Хичээлийн тодорхойлолт нь дараах мэдээллийг агуулна:

- (a) хичээлийн нэр, код
  - (b) санал болгосон улиралд хичээлийн үргэлжлэх хугацаа, санал болгосон хичээлийн давтамж
  - (c) хичээлийг амжилттай судалж дуусах болон цуглуулах багц цагийн хэмжээ
  - (d) хичээлийн цаг болон бие даан суралцах цагт хуваасан цагаар тооцсон ачаалал
  - (e) хичээлийг хариуцсан багш (хариуцсан багш)
  - (f) хичээл заах хэл
  - (g) хүрэхээр төлөвлөсөн суралцахуйн үр дүн/мэргэжлийн агуулга
  - (h) заавал судлах ном зүй
  - (i) хичээлийн хэлбэр
  - (j) үнэлгээний аргууд
  - (k) хамаарах хөтөлбөр
  - (l) өмнөх холбоос
  - (m) хичээлийн шалгалтын хэлбэр
  - (n) үнэлгээ
- (5) Бүх хичээлийн тодорхойлолтыг хөтөлбөрийн хичээлийн гарын авлагад хураангуйлан харуулав.
- (6) Хичээл хариуцсан шалгалт авах явцыг зохицуулах, хичээлийн хүрээнд үнэлэх санал гаргах үүрэгтэй.

## **§7. Үндсэн ба сонгон суралцах хичээл**

- (1) Үндсэн хичээлүүд нь сургалтын хөтөлбөрийн заавал судлах хэсэг бөгөөд оюутнууд судалсан байна.
- (2) Үндсэн хичээлд нэмэлт болгож оюутнууд суралцах хугацаандаа сонгон суралцах хичээлээс тодорхой багц цагийн хичээлүүдийг суралцана. Судалбал зохих багц цагийн хэмжээг сургалтын төлөвлөгөөнд дурдсан болно.
- (3) Сонгон суралцах хичээлүүд нь техникийн болон техникийн бус байж болно. Оюутан боломжтой эсэхээс нь хамааран хэд хэдэн сонгон суралцах хичээлээс сонгоно. Журмын дагуу сонгон суралцах хичээлийг судлах оюутны тоо багадаа 5 байна.
- (4) Оюутнууд танхимын хичээлийн эхний 2 долоо хоногийн дотор сонгон суралцах хичээлийг үзэж судлахгүй байж болно. Эрчимжүүлсэн сургалтын хувьд тухайн хичээлийг санал болгосон эхний 7 хоногийн дотор байна. Оюутнууд сонгон суралцах хичээлийг үргэлжлүүлэн судалсаар байх тохиолдолд шалгалтын журмын дагуу хичээлийг судалж дуусгах хэрэгтэй.
- (5) Хөтөлбөрийн зохицуулагчтай тохиролцон бусад Бакалаврын хөтөлбөрийн энгийн үндсэн хичээлүүдийг сонгон суралцах хичээлд тооцуулж болно.
- (6) Оюутнууд сургалтын төлөвлөгөөнд шаардсан дээд хэмжээгээр сонгон суралцах Хичээлүүдийг судлах эрхтэй.
- (7) Оюутнууд Монгол эсвэл гадаад дахь түнш сургуулиудаас санал болгосон хичээлүүдийг судалж болох ба үзэж судалсан хичээлүүдээ МГТИС-д суралцах хугацаандаа тооцуулна. Хичээлийг судалж эхлэхээс өмнө Шалгалтын комиссгоор хичээлийн сонголтыг

зөвшөөрүүлнэ.

### **§8. Багц цаг, суралцагчийн ачаалал ба хичээлийн цаг**

- (1) Хичээлүүдийг амжилттай үзэж судлахын тулд багц цаг онооно.
- (2) Багц цаг нь хичээлийн ачааллыг илэрхийлнэ. Европын кредит цуглуулах, шилжүүлэх систем ("ЕКЦШС")-ийг үндэслэн нэг багц цаг нь 30 цаг (нэг цаг 60 минуттай тэнцэнэ)-ийн ачааллыг хэлнэ. Үүнд хичээлийн цаг, гэрийн даалгавар, ангийн ажил, шалгалтад бэлдэх, шалгалт өгөх, бие даан суралцахад зарцуулсан цаг орно.
- (3) Хичээлийн цагийн хэмжээг хичээлийн цагаар тодорхойлно. Хичээлийн нэг цаг нь танхимын хичээлийн 7 хоног бүрд 45 минут байна. Шаардлагатай бол хичээлийн тодорхойлолтод зааснаас өөрөөр хичээлийг блок хэлбэрээр 7 хоногт ноогдох хичээлийн цагийг ихэсгэн цөөн 7 хоногт зааж болно.

### **§9. Гүйцэтгэл ба хичээлийн үнэлгээ**

- (1) Оюутан танхимын хичээлд заавал сууна. Оюутнууд хичээлийн 80%-д сууснаар хичээлийн шалгалтад орох урьдчилсан нөхцлийг хангана.
- (2) Улирлын гүйцэтгэл өөр өөр хэлбэртэй байж болно. Жишээлбэл, даалгавар гүйцэтгэх, лабораторийн ажил, дадлагын ажил, хяналттай тест, шалгалт өгөх, илтгэл тавих, гэрийн даалгавар хийх гэх мэт. Гүйцэтгэлд дүн тавьж болно. Улирлын гүйцэтгэлд тавих шаардлага нь багшаас хамаарна. Хичээлийн эхэнд эдгээр шаардлагын талаар оюутнуудад мэдэгдэнэ.
- (3) Хичээлийн эцсийн үнэлгээний дэлгэрэнгүй (шалгалт, тэнцсэн/тэнцээгүй гэх мэт)-г хичээлийн тодорхойлолтод дурдав. Нэмэлт мэдээллийг Хэсэг В: Шалгалтын журамд дурдав.

### **§10. Хөтөлбөрийн зохицуулагч**

- (1) Хөтөлбөрийн зохицуулагч Бакалаврын зэрэг олгох хөтөлбөр хэрэгжүүлэгч Факультетыг төлөөлөн хөтөлбөрийг зохион байгуулна. Тэрээр сургалтын төлөвлөгөө, хичээлийн гарын авлага, Сургалтын болон шалгалтын журамд тогтмол үзлэг шалгалт хийн, шинэчилсэн найруулгад нь саналаа оруулна.
- (2) Хөтөлбөрийн зохицуулагч элсэлтийн шаардлага, шалгалт, хичээл сонголт, гадаадад суралцах үе шат, дадлага ажил, ажлын байр, мэргэжлээ солих, бусад их, дээд сургуулиас шилжин суралцах зэрэг хөтөлбөртэй холбоотой бүх асуудлаар оюутнуудад зөвлөнө.

## **Хэсэг В – Шалгалтын журам**

### **I. Шалгалтын тодорхойлолт**

#### **§1. Бакалаврын хөтөлбөрийн шалгалтын зорилго**

- (1) Бакалаврын хөтөлбөрийн шалгалт нь оюутны төгсөх үед мэргэжлийн ур чадвар эзэмшсэн баталгаа болно. Энэхүү шалгалтын зорилго нь суралцагч мэргэжлээрээ ажиллахад шаардагдах мэдлэг, ур чадвар, хандлагаар дамжуулан шаардлагатай чадваруудыг эзэмшсэн, мэргэжлийнхээ салбар хоорондын харилцаа холбоог ойлгосон, ажлын ур чадвар олж авсан ба шинжлэх ухааны арга зүйн дагуу цаашид бие даан хөгжих эсэхийг тодорхойлоход оршино.
- (2) Бакалаврын хөтөлбөрийн шалгалт нь бүх хичээлийн шалгалт, бакалаврын дипломын ажил, хамгаалалтаас бүрдэнэ.

#### **§2. Хичээлийн шалгалт**

- (1) Хичээлийн шалгалт нь хичээлийн эцсийн шалгалт юм. Суралцагч зөвхөн хичээлийн бүх багц цагийн багадаа 80%-д сууснаар хичээлийн шалгалт өгөх эрхтэй болно.
- (2) Хичээлд тооцсон эцсийн үнэлгээ нь улирлын гүйцэтгэл болон шалгалтын үнэлгээнээс бүрдэнэ.
- (3) Журмын дагуу хичээлийн гүйцэтгэлийг эцсийн үнэлгээний 30%-д, шалгалтыг эцсийн үнэлгээний 70%-д тооцно. Онцгой тохиолдолд жишээлбэл, лабораторийн хичээлийн хувьд улирлын гүйцэтгэлийг эцсийн үнэлгээний 100%-д тооцож болно. Дэлгэрэнгүйг хичээлийн тодорхойлолтод дурдав.
- (4) Улирлын гүйцэтгэл нь 100% тооцогдсон хичээлийг багадаа 60% эсвэл "тэнцсэн" дүнгийн үнэлгээтэй суралцаагүй бол хичээлийн тодорхойлолтод өөрөөр заагаагүй тохиолдолд хичээлийг дахин судална. Инженерийн зуны хөтөлбөрийн сонгон суралцах хичээл нь энэхүү дүрмийн онцгой тохиолдолд тооцогдоно. Энэхүү хичээлийг дахин судлах боломжгүй.

#### **§3. Шалгалтын агуулга, төрөл**

- (1) Шалгалтын агуулга нь хичээлийн тодорхойлолтон дахь суралцахуйн үр дүнд тулгуурлана.
- (2) Шалгалтыг бичгээр, амаар эсвэл тухайн хичээлд тохирсон бусад хэлбэрээр авч болно. Хичээл бүрийн тухайд шалгалт авах хэлбэрүүдийг хичээлийн гарын авлагад тодорхойлно.
- (3) Хичээлийн тодорхойлолт сонголттой байвал шалгагч багш нар бүртгэлийн өдрөөс өмнө шалгалтыг амаар эсвэл бичгээр авах эсэхийг мэдэгдэнэ.

- (4) Шалгагч багш нар шалгалтад ямар хэрэгсэл, туслах материал ашиглахыг шалгалтаас өмнө оюутнуудад мэдэгдэнэ.
- (5) Суралцагч шалгалтаас өмнө аль хэдийн тодорхой болсон хувийн шалтгаан (өвдөх, жирэмслэх, хөгжлийн бэрхшээл, хүүхэд, гэр бүлийн гишүүдээ асрах гэх мэт)-ы улмаас сургалтын журмын дагуу шалгалтаа өгч чадахгүй бол тэрээр §6-т заасны дагуу даалгаврын гүйцэтгэлийн хугацааг сунгах, шалгалт, танилцуулга, хамгаалалтыг хойшлуулах зэргээр шалгалтыг бусад хэлбэрээр өгөх зөвшөөрөл авахаар Шалгалтын комисст бичгээр хандана. Дээр дурдсан шалтгааныг баримтжуулах эмнэлгийн магадалгаа эсвэл өөр зохих нотолгоог өргөдлийн хамт ирүүлнэ.

#### **§4. Бичгийн шалгалт**

- (1) Бичгийн шалгалтын үргэлжлэх хугацааг холбогдох хичээлийн тодорхойлолтод зааж өгнө. Бичгийн шалгалтын хугацаа багадаа 60 минут, ихдээ 180 минут байна.
- (2) 120 гаруй минутаас дээш үргэлжлэх шалгалтыг дунд нь завсарлагатайгаар 2 хэсэгт хуваан авна. Шалгалтын эхний хэсгийг завсарлагаас өмнө авч дуусах ба шалгалтын материалыг хураан авна.
- (3) Бичгийн шалгалтыг багадаа 2 шалгагч багш эсвэл хянагч багшаар туслуулсан нэг шалгагч багш авна.

#### **§5. Аман шалгалт**

- (1) Аман шалгалтыг шалгагч болон зөвлөх багш авна. Хичээлийг 2 багш заадаг бол шалгалтыг 2 шалгагч багш авна.
- (2) Аман шалгалтын үргэлжлэх хугацааг холбогдох хичээлийн тодорхойлолтод заасан байна. Суралцагч бүрийн хувьд аман шалгалтын хугацаа багадаа 15 минут, ихдээ 60 минут байна.
- (3) Аман шалгалтын үндсэн сэдэв, дүнг шалгагч багш нар хурлын тэмдэглэлд тэмдэглэнэ.

#### **§6 Өөр хэлбэрийн шалгалтын арга**

- (1) Гол төлөв дадлагын ажил, семинар, төсөл буюу ангийн ажлын хэмжээнд шалгалтыг өөр хэлбэрээр авдаг. Эдгээр шалгалтууд нь бичих даалгавар, танилцуулга, тайлан бэлдэх болон бусад хэлбэрээр байж болно. Багаар ажиллах төсөл буюу ангийн ажил байх тохиолдолд оюутан бүрийн оролцоо тодорхой, харагдахуйц байна.
- (2) Өөр хэлбэрийн шалгалтын үргэлжлэх хугацаа, хэмжээ, түүнд бэлтгэх хугацаа, ирүүлэх материалыг холбогдох хичээлийн тодорхойлолтод зааж өгнө.
- (3) (1)-т заасны дагуу бичих даалгавар болон Бакалаврын дипломын ажлаа ирүүлэхдээ суралцагч тухайн материалын зохиогч болохоо мөн материалд дурдсанаас өөр туслах материал, эх сурвалжийг ашиглаагүй болохоо бичгээр баталгаажуулна.



## II. Шалгалтыг зохион байгуулах

### §7. Шалгалтын комисс

- (1) Шалгалтын комисс боловсролын зэрэг олгох хөтөлбөр бүрийн шалгалтыг зохион байгуулна. Өөрөөр хэлбэл нэг комисс олон хөтөлбөрийн шалгалтыг хариуцаж болно.
- (2) Шалгалттай холбоотой бүх асуудлын хувьд Шалгалтын комисс Сургалтын болон шалгалтын журмын мөрдөлтийг хангаж ажиллана. Комисс нь эдгээр журамд тусгагдсан хариуцлагаас гадна шаардлагатай чухал шийдвэрүүдийг мөн гаргана. Шалгалтын комисс нь дараах асуудлуудтай холбоотой шийдвэрийг гаргана:
  - (a) шалгалтад орох эрх олгох
  - (b) хүсэлтийг үндэслэн шалгалт өгөх өөр хэлбэрийг батлах
  - (c) шалгагч багш нарыг томилох
  - (d) дээд боловсрол олгох бусад их, дээд сургуулиудад сурсан хугацаа, дүнгийн үнэлгээ, багц цагийг тооцох
  - (e) шалгагч багш нар санал зөрөлдсөн тохиолдолд шалгалтын эцсийн дүнгийн үнэлгээний талаар шийдвэр гаргах
  - (f) удирдагчтай зөвшилцөн Бакалаврын дипломын ажлын сүүлийн хугацааг сунгах эсэх талаар шийдвэр гаргах
  - (g) Бакалаврын дипломын ажлыг үнэлэх хөндлөнгийн шалгагч багшийг томилох
  - (h) эдгээр журмыг зөрчсөн тохиолдолд үр дагаврыг тодорхойлох
  - (i) шалгалтыг хүчингүйд тооцох
  - (j) гомдлыг шийдвэрлэх
  - (k) Сургалтын болон шалгалтын журмыг сайжруулах талаар санал, зөвлөмж гаргах.
- (3) Шалгалтын комисс 5 гишүүнтэй байна (гурван профессор, нэг багш, нэг оюутан). Факультет Шалгалтын комиссын гишүүдийг томилно. Зөвхөн нэг л факультет хоорондын Шалгалтын комисстой бол Эрдмийн зөвлөл Комиссыг батлах ба Захирлын тушаалаар томилно. Комиссын оюутны төлөөллийг оюутны зөвлөл санал болгоно. Мөн Сургалт болон оюутны асуудал хариуцсан албаны дарга Комисст зөвлөгөө өгч ажиллана.
- (4) Шалгалтын комиссын гишүүдийг 2 жилийн, оюутнуудыг нэг жилийн хугацаатай томилно. Улируулан ажиллуулж болно.
- (5) Шалгалтын комисс анхны хурлаараа Дарга болон Дэд даргаа сонгоно. Шалгалтын комиссын зөвшөөрөлтэйгөөр (2)-р зүйлийн дагуу хүлээх Комиссын үүргийг Даргад шилжүүлж болно.
- (6) Шалгалтын комиссын хурлын ирц багадаа гишүүдийн тал нь хуралд оролцоноор бүрдэнэ. Хуралд оролцогч гишүүдийн олонхийн саналаар шийдвэр гаргана. Онцгой тохиолдолд хурлыг хуралдуулахгүйгээр бичгээр тохиролцон шийдвэр гаргаж болно. Санал тэнцсэн тохиолдолд Комиссын даргын саналаар шийднэ.
- (7) Шалгалтын комиссын дарга комиссын хурлын урилгыг багадаа хоёр өдрийн өмнө урьдчилан хүргүүлнэ.
- (8) Шалгалтын комиссын гишүүд бүх шалгалтад байлцах ба шалгалттай холбоотой бүх

материалтай танилцах эрхтэй.

- (9) Шалгалтын комиссын гишүүд мэргэжлийн нууцлалыг хадгална.

### **§8. Шалгагч, зөвлөх, хянагч багш нар**

- (1) Профессор болон багш нар зааж байгаа эсвэл заах боломжтой хичээлийнхээ шалгалтыг зохион байгуулах эрхтэй.
- (2) Бие даан тусгай хичээл заахаар томилогдсон гадны сургагч заадаг хичээлийнхээ шалгалтыг зохион байгуулж болно.
- (3) Шалгалтын комисс шалгалтыг зохион байгуулах эрх аваагүй шалгагч багш нарыг томилох ба тэдгээрийг Сургалт болон оюутны асуудал хариуцсан албанд мэдэгдэх үүрэгтэй.
- (4) Шаардлагатай тохиолдолд Шалгалтын комисс шалгалтыг хамтран зохион байгуулах хэд хэдэн шалгагч багшийг томилж болно.
- (5) Бичгээр авах шалгалтын хянагч багш нарыг шалгагч багш томилно. Хянагч багшийн хувьд холбогдох хичээлд мэргэшсэн байх шаардлага тавихгүй.
- (6) Аман шалгалтын зөвлөх багш нарыг шалгагч багш томилно. Зөвлөх багш шалгалтанд шаардагдах эсвэл дүйцэхүйц ур чадвартай байх ёстой.
- (7) Шалгагч болон зөвлөх багш нар тус тусдаа болон бодитойгоор шалгалтыг үнэлнэ.
- (8) Шалгагч, зөвлөх, хянагч багш нар мэргэжлийн нууцлалыг хадгална.

### **III. Шалгалтын хугацаа, шаардлага, бүртгэл, шалгалтад орохгүй байх**

#### **§9. Шалгалтын хугацаа**

- (1) Шалгалтыг гол төлөв хичээлийг зааж дууссаны дараагаас эхлэх шалгалтын хугацаанд авна. Дахин өгөх шалгалтыг улирал бүрийн эхэнд дахин шалгалтын хугацаанд авна.
- (2) Шаардлагатай тохиолдолд шалгалтыг шалгагч багш болон оюутан (зөвхөн аман шалгалтын хувьд)-тай зөвшилцөн, Шалгалтын комиссын шийдвэрийг үндэслэн ердийн шалгалтын хугацаанаас өөр хугацаанд авч болно.
- (3) Шалгалтын тов, бүртгэлийн хугацаа нь хичээлийн шинэ жил эхлэхээс өмнө тодорхой болох ба хичээлийн жилийн хуанлийн нэг хэсгийг бүрдүүлнэ.
- (4) Шалгагч багш нартай зөвшилцөн Сургалт ба оюутны асуудал хариуцсан алба шалгалт авах өдөр, цаг, газар, хичээлийн нэр, шалгагч багш нарын нэрсийг шалгалт авах хугацаа эхлэхээс багадаа 2 долоо хоногийн өмнө мэдээлнэ. Энэхүү шалгалтын төлөвлөгөө өөрчлөгдөх шаардлага гарсан тохиолдолд шалгалтын өдрийг зөвхөн Шалгалтын комиссын зөвшөөрөлтэйгөөр дахин тогтооно.

## §10. Шалгалтад ороход тавих шаардлага

- (1) Хэрэв суралцагч зөвхөн:
  - (a) МГТИС-д элсэн орсон;
  - (b) Хичээлийн танхимд орох цагаас багадаа 80%-д суусан;
  - (c) МГТИС-ийн бүх боломжит дахин шалгалт эсвэл бусад их, дээд сургуулийн дүйцэхүйц шалгалтад хараахан амжилтгүй дүн үзүүлээгүй бол хичээлийн шалгалтад орох боломжтой.
- (2) Суралцагч сургууль эсвэл зэргийн хөтөлбөрөө өөрчилсөн бол тухайн суралцагчийн гаргасан хүсэлтийг үндэслэн Шалгалтын комисс бүртгэлийн өдөр элсэн орох үүргээс чөлөөлж болно. Энэ тохиолдолд мөн Комисс нь Хэсэг В §2 (3)-г үл хөндөн, хичээлийн шалгалтыг холбогдох хичээлийн эцсийн дүнгийн үнэлгээнд 100% тооцох, тооцохгүй эсэхийг шийднэ.
- (3) Суралцагч гагцхүү Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуульд элсэн орсон тохиолдолд Бакалаврын дипломын ажлын сэдэв авах эрхтэй.
- (4) Суралцагч (1)-т заасан бүх шалгалтад орох шаардлагыг хангасан бол хичээлийн шалгалтыг заавал өгөх ёстой. Багш (1) b -н дагуу мэдээллийг Кампус менежментийн системд баталгаажуулах ёстой. Суралцагч энэхүү эхний хичээлийн шалгалтад бүртгүүлэх шаардлагагүй. Онцгой тохиолдолд Шалгалтын комисс заавал өгөх үүргээс өөрөөр шийдэж болно.
- (5) Суралцагч хичээлд суух шаардлагын 80%-ийг хангаагүй тохиолдолд эхний заавал өгөх шалгалтад "амжилтгүй" дүн үзүүлсэнд тооцно. Суралцагч гүйцэтгэлийн шаардлага зэрэг хичээлийг дахин судлах хэрэгтэй. Хичээлд суух шаардлагыг тооцохгүй.
- (6) Хэрэв суралцагч хичээлд суух шаардлагыг дутуу хангасны улмаас дараалан 3 эсвэл түүнээс дээш заавал судлах хичээлүүдийг судлаагүй бол суралцагч нь бусад хөтөлбөрийн хичээлд суухгүйгээр сургуулийн эдгээр хичээлүүдийг санал болгох улиралд эдгээр 3 буюу түүнээс дээш хичээлүүдийг дахин судална. Гэхдээ суралцагч эдгээр 3 буюу түүнээс дээш хичээлүүдийг дараалан дахин судлах тохиолдолд хичээлийн тодорхойлолтод заасан гүйцэтгэл болон хичээлд суух шаардлагыг мөрдөнө.
- (7) Эхний дахин өгөх шалгалтад орохын тулд суралцагч Сургалт ба оюутны асуудал хариуцсан албанд бүртгүүлэх хэрэгтэй. 2 дахь дахин өгөх шалгалтад орохын тулд суралцагч Сургалт ба оюутны асуудал хариуцсан албанд бичгээр хандах ба зөвхөн хүсэлтийг нь зөвшөөрсөн тохиолдолд бүртгүүлэх боломжтой.
- (8) Шалгалтын комисс суралцагч (1) а) - с)-н дагуу шалгалт өгөх шаардлагыг хангасан эсэхийг шалгана. Сургалт ба оюутны асуудал хариуцсан алба Шалгалтын комиссоос хэвлэн гаргасан шалгалтад орох суралцагчдын нэрсийг бэлдэнэ.
- (9) Дараах тохиолдолд шалгалтад орох эрхийг олгохгүй. Хэрэв:
  - (a) суралцагч шалгалтад орох шаардлага болон (1) - (3)-т тодорхойлсон журмыг биелүүлээгүй
  - (b) суралцагч бүртгэлийн хугацаанд дахин өгөх шалгалтад бүртгүүлээгүй.
- (10) Эргэлзээ төрсөн тохиолдолд Шалгалтын комиссоор шийдвэрлүүлнэ.

## **§11. Суралцсан хугацаа ба шалгалтыг тооцох**

- (1) Монгол эсвэл гадаад дахь өөр дээд боловсрол олгох байгууллагад үзэж судалсан хичээл ба өгсөн шалгалтыг Шалгалтын комисс тэдгээр нь МГТИС-ийн холбогдох зэрэг олгох хөтөлбөрийн хичээл, шалгалтаас зөрөөгүй л бол тооцно.
- (2) Хичээл болон шалгалтыг тооцоогүй тохиолдолд Шалгалтын комисс тооцуулахыг хүссэн хичээл, шалгалт ба МГТИС-ийн холбогдох зэрэг олгох хөтөлбөрийн хичээл хоорондын ялгааг нотлон харуулна. Ялгаа нь хичээл ба шалгалтын чанар, түвшин, суралцагчийн үр дүн, ачаалал, хэлбэр байж болно. Хүсэлт гаргагч хичээлийг тооцуулахын тулд дүнгийн тодорхойлолт, холбогдох хичээлийн тодорхойлолт, сургалтын хөтөлбөр, бусад шаардлагатай материалыг ирүүлнэ.
- (3) Солилцооны хөтөлбөрийн хувьд гадаадад үзэж судалсан хичээлийг тооцохдоо тухайн оюутныг суралцахаар явахаас өмнө оюутан, түнш сургууль, МГТИС-ийн Шалгалтын комисс хооронд байгуулсан Суралцах гэрээг үндэслэнэ.
- (4) Дээд боловсрол олгох байгууллагаас гадуур албан бусаар олж авсан мэдлэг, ур чадвар, чадамжийг судалж байгаа хөтөлбөрийн хичээлийг үзэж судлан олж авсан мэдлэг, ур чадвар, чадамжаас их зөрөөгүй л бол тооцно.
- (5) Дүгнэж хэлэхэд тооцуулах хүсэлт гаргасан хичээл, шалгалтыг МГТИС-ийн зэрэг олгох хөтөлбөрийн хамгийн ихдээ 120 багц цагт дүйцүүлнэ.
- (6) Хичээл болон шалгалтыг тооцсон тохиолдолд дүнгийн үнэлгээг Европын кредит цуглуулах, шилжүүлэх системийн хэрэглэгчийн гарын авлагын дүрмийг үндэслэн Шалгалтын комиссын шийдвэрээр шилжүүлнэ.
- (7) Хичээл болон шалгалтыг сүүлийн 5 жилийн дотор үзэж судлан, өгсөн болсон бол тэрхүү хичээл болон шалгалтыг тооцно. Шалгалтын комисс хүсэлт гаргагчийн одоогийн мэдлэгийн статусыг харгалзан өмнө нь үзэж судалсан хичээл, шалгалтыг тооцох эсэхийг шийднэ. Тооцохоос татгалзсан бол хүсэлт гаргагчид тийнхүү тооцоогүй шалтгаанаа тайлбарлана.
- (8) Шаардлагатай бол Шалгалтын комисс шийдвэр гаргахдаа шалгагч багшийг оролцуулах эсвэл оюутнаас мэдлэг, ур чадвар, чадамжаа нотлох зорилгоор шалгалт өгөхийг хүсэж болно.

## **§12. Бүртгэл**

- (1) Бүх шалгалтыг дахин өгөх суралцагч Сургалт ба оюутны асуудал хариуцсан албанд бүртгүүлнэ.
- (2) Бүртгэл нэг 7 хоногийн хугацаанд явагдах ба шалгалт эхлэхээс нэг 7 хоногийн өмнө дуусна.
- (3) Сургалт ба оюутны асуудал хариуцсан алба цахимаар болон бичгээр бүртгэл эхлэх, дуусах хугацааг мэдээлнэ.
- (4) Хэсэг В §9 (2)-н дагуу тусгай шалгалтын товын хувьд ч мөн адил суралцагч шалгалтаас нэг 7 хоногийн өмнө бүртгүүлнэ.

### **§13. Шалгалт өгөхгүй байх, сүүлийн хугацаа**

- (1) Суралцагч өвдсөн эсвэл бусад ноцтой шалтгааны улмаас шалгалтаа өгч чадахгүй бол тэрээр шалтгааныхаа талаар Сургалт ба оюутны асуудал хариуцсан албанд тэр даруйдаа бичгээр мэдэгдэнэ.
- (2) Өвдсөн бол хэзээнээс өвдөж эхэлсэн, боломжтой бол хэзээ хүртэл өвчтэй байх мөн шалгалт өгөх боломжгүйг тэмдэглэсэн эмчийн магадалгааг үзүүлнэ. Эмчийн магадалгааг Сургалт ба оюутны асуудал хариуцсан албанд өвдсөнөөсөө хойш ажлын 3 хоногийн дотор хүргүүлнэ.
- (3) Суралцагчийн халамжид байдаг хүүхэд өвдөх тохиолдлыг тухайн суралцагч өөрөө өвдсөнтэй адил түвшинд авч үзнэ. Эргэлзээтэй тохиолдолд албан ёсны эмнэлгийн ажилтнаас магадалгаа авчрахыг шаардаж болно.
- (4) Суралцагч шалтгаангүйгээр шалгалтаа өгөөгүй эсвэл шалтгааныг нь Сургалт ба оюутны асуудал хариуцсан алба хүлээн зөвшөөрөх боломжгүй нөхцөлд Шалгалтын комисс түүнийг шалгалтад "тэнцээгүй"-д тооцно.
- (5) Мөн (1)-(3)-т заасан журам нь шалгалтад бүртгүүлэх хугацаа, шалгалттай холбоотой өгсөн бичих даалгаварт тогтоосон хугацааг мөн хамаарна.
- (6) Эргэлзээтэй тохиолдолд Шалгалтын комисс шалгалтад ороогүй шалтгаан, шалгалтын сүүлийн хугацааг хүлээн зөвшөөрөх боломжтой үгүйг шийднэ.

## **IV. Бакалаврын дипломын ажил**

### **§14. Нэр томъёоны тодорхойлолт**

- (1) Бакалаврын дипломын ажил ба хамгаалалтын хувьд суралцагч шинжлэх ухааны эсвэл инженерийн арга зүйг ашиглан тодорхой хугацааны дотор бие даан судалж байгаа салбартаа тулгарсан асуудлыг шийдвэрлэж чадна гэдгээ нотолно. Түүнчлэн, суралцагч асуудлыг танилцуулан, судалгаа шинжилгээний ажлаа бичгээр болон аман хэлбэрээр бэлтгэнэ.
- (2) Бакалаврын дипломын ажил, хамгаалалтын дэлгэрэнгүйг хичээлийн тодорхойлолтод тусгана.

### **§15. Дипломын ажлын сэдэв авахад тавих шаардлага, даалгавар, дипломын ажлыг хүргүүлэх**

- (1) Бакалаврын дипломын ажлын сэдэв нь Бакалаврын зэрэг олгох хөтөлбөрийн агуулгатай холбоотой байна. Сэдвийг МГТИС-ийн профессор эсвэл багш тодорхойлж батлан оюутанд өгнө. Боломжтой бол суралцагчийн санал болгосон сэдвийг харгалзан үзнэ.
- (2) Суралцагч багадаа 180 багц цаг цуглуулсан бол тэрээр Бакалаврын дипломын ажил хийхээр Сургалт ба оюутны асуудал хариуцсан албанд бүртгүүлж болно. Сургалт ба

оюутны асуудал хариуцсан алба дипломын ажлын сэдвийг бүртгүүлэх өдөр, дипломын ажлын сэдэв, дипломын ажлыг хүргүүлэх өдрийг тухайн суралцагчийн хувийн хэрэгт бичиж тэмдэглэнэ.

- (3) Хичээлийн тодорхойлолтод Бакалаврын дипломын ажил бичих ба Сургалт ба оюутны асуудал хариуцсан албанд хүргүүлэх хугацааг тодорхойлно. Журмын дагуу Бакалаврын дипломын ажил бичих хугацаа ихдээ 6 сар байна. Бакалаврын ажлын сэдэв нь тогтоосон хугацааны дотор дипломын ажлыг бичиж дуусгах боломжийг олгох байдлаар боловсруулагдсан байна. Онцгой тохиолдолд Шалгалтын комисс сүүлийн хугацааг 8 долоо хоногоор сунгаж болно. Энэхүү үйл явц нь Хэсэг В §13-н журмын дагуу явагдана.
- (4) Суралцагч нь ажлыг бичиж дуусах хугацааны дунд хүрэхээс өмнө буюу эхэлснээс хойш 2 сарын дотор дипломын ажлын сэдвийг буцааж болно. Үүнийг "тэнцээгүй"-д тооцохгүй. Дипломын ажлын сэдвийг буцаамагц, шинэ сэдвийг даруй өгнө. Энэ үед шинээр тогтоох сүүлийн хугацаа ба (3)-н дагуу бичих хугацааг дахин тодорхойлно. Шинэ тогтоосон хугацаа болон сэдвийг хувийн хэрэгт тэмдэглэнэ. Шинээр олгосон сэдвийг буцаах боломжгүй.
- (5) Суралцагч Сургалт ба оюутны асуудал хариуцсан албанд Бакалаврын дипломын ажлын 2 хэвлэсэн хувийг хүргүүлнэ. Бакалаврын дипломын ажилд интернет болон бусад бүх хэрэгслээс авсан эх сурвалж зэрэг бүх эх сурвалжийн бүрэн индекс, мөн Хэсэг В §6 (3)-т дараах албан ёсны мэдэгдлийг дурдана. Бакалаврын дипломын ажлын цахим хувилбарыг заавал шаардах ба мөн Сургалт ба оюутны асуудал хариуцсан алба, шалгагч багш нарт хүргүүлэх сүүлийн хугацаанаас өмнө хүргүүлнэ.
- (6) Хугацаандаа Бакалаврын дипломын ажлаа ирүүлээгүй бол "амжилтгүй" дүн үзүүлсэнд тооцно.
- (7) Бакалаврын дипломын ажлын дүнгийн үнэлгээтэй хувь нь тухайн суралцагчийн шалгалтын хувийн хэргийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

## **§16. Дипломны удирдагч ба үнэлгээ**

- (1) Журмын дагуу Бакалаврын дипломын ажлыг МГТИС-ийн профессор эсвэл удирдагч багш үнэлж дүгнэнэ.
- (2) Бакалаврын дипломын ажлыг МГТИС эсвэл өөр сургуульд хийж болно. Өөр сургуульд хийсэн тохиолдолд тухайн сургуулийн профессор болон Шалгалтын комиссын томилсон МГТИС-ийн профессор нар хамтран удирдана.
- (3) Бакалаврын дипломын ажлыг багадаа 2 шалгагч багш тус тусдаа бичгээр үнэлнэ. Нэг шалгагч багш нь удирдагч байна. Бакалаврын дипломын ажлыг (2)-т дурдсаны дагуу хамтран удирдсан бол хоёулаа шалгагч багш байна. Тэдэнд нэмэлт болгон Шалгалтын комисс гуравдагч шалгагч багшийг томилно.
- (4) Суралцагч Шалгалтын комисст шалгагч багш санал болгож болно. Шалгалтын комисс үндэслэлтэй шалтгаанаар суралцагчийн саналаас татгалзаж болно.
- (5) Бичгэн үнэлгээг суралцагчийн шалгалтын хувийн хэрэгт бичиж тэмдэглэнэ. Үнэлгээг 4 долоо хоногийн дотор хийж дуусгана.

- (6) Бүх шалгагч багш нарын багадаа 60% нь "тэнцсэн" гэсэн үнэлгээ өгсөн тохиолдолд Бакалаврын дипломын ажлыг "тэнцсэнд"-д тооцно. Хэрэв үнэлгээнүүд ялгаатай бол эцсийн үнэлгээ нь бүх дүнгийн үнэлгээний дундаж байна.
- (7) Нэг шалгагч багш Бакалаврын дипломын ажлыг "тэнцээгүй"-д тооцсон бол Шалгалтын комисс өөр дүнгийн үнэлгээ гаргуулахаар нэмэлт шалгагч багш томилно. Хэрэв энэхүү шалгагч багш мөн дипломын ажлыг "тэнцээгүй"-д тооцвол ажлыг "тэнцээгүй"-д тооцно. Бусад бүх тохиолдолд дипломын ажлын эцсийн дүнгийн үнэлгээ нь бүх шалгагч багш нарын өгсөн дүнгийн үнэлгээний дундаж байна.
- (8) Бакалаврын дипломын ажлыг нийтийн өмнө нээлттэй хамгаална. Гагцхүү Бакалаврын дипломын ажлыг "тэнцсэн"-д тооцсон тохиолдолд суралцагч хамгаалалтанд орох боломжтой. Суралцагч хамгийн цаад тал нь хамгаалалтаас нэг өдрийн өмнө бичгэн үнэлгээтэй танилцах эрхтэй. Хамгаалалт нь Бакалаврын дипломын ажлыг хүргүүлснээс хойш 8 долоо хоногийн дотор явагдана. Суралцагчийн танилцуулга ойролцоогоор 20 минут, хэлэлцүүлэг ихдээ 40 минут явагдана. Хамгаалалтын дүнгийн үнэлгээ нь бүх шалгагч багш нарын дүнгийн үнэлгээний дундаж байна.
- (9) Бакалаврын дипломын ажлын эцсийн дүнгийн үнэлгээ нь дипломын ажлын дүнгийн үнэлгээ, 4:1 жинтэй хамгаалалтын үнэлгээнээс бүрдэнэ. Хамгаалалт багадаа "тэнцсэн"-д тооцогдсон байна.

## V. Шалгалтын үнэлгээ

### §17. Дүнгийн тодорхойлолт

(1) Дүнгийн үнэлгээний системийг дараах байдлаар тодорхойлно:

Үсгэн үнэлгээ	Тоон үнэлгээ	Гүйцэтгэлийн хувь	Үнэлгээний тайлбар
A	4.0	95-100	онц сайн гүйцэтгэл
A-	3.7	90-94	
B+	3.3	87-89	дунджаас нилээд дээгүүр сайн гүйцэтгэл
B	3.0	83-86	
B-	2.7	80-82	
C+	2.3	77-79	дундаж гүйцэтгэл
C	2.0	73-76	
C-	1.7	70-72	
D+	1.3	65-69	доголдлыг үл харгалзан

D	1.0	60-64	шаардлагыг хангасан гүйцэтгэл
F	0	0-59	хангалтгүй гүйцэтгэл

## §18. Дүн

- (1) Шалгагч багш суралцагчийн шалгалтын дүнгийн үнэлгээг гаргана. Дүнгийн үнэлгээ гаргахад нэгээс дээш тооны шалгагч багш оролцсон бол эцсийн дүнгийн үнэлгээ нь гүйцэтгэлийн хувиар илэрхийлсэн дүнгийн үнэлгээний дундаж байна. Энэ нь Хэсэг В § 16 (6), (7)-д нөлөөлөхгүй.
- (2) Хичээлийн шалгалтын үнэлгээг 2 долоо хоногийн дотор хийнэ. Бакалаврын дипломын ажлын хувьд Хэсэг В § 16 (5) хамаарна.
- (3) Багадаа 60%-ийн дүнгийн үнэлгээтэй бол шалгалтад "тэнцсэн"-д тооцно. 60-с доош хувийн үнэлгээтэй бол "тэнцээгүй"-д тооцно. Бүх хичээлийн шалгалтын гүйцэтгэлийн хувиар илэрхийлсэн оноог бүхэлдэх буюу бүхэл тоогоор илэрхийлнэ.
- (4) Сургалтын төлөвлөгөөнд сонгосон чиглэлээр цуглуулбал зохих багц цагийн хэмжээг тодорхойлдог. Бакалаврын шалгалтын дүнг тооцохдоо сонгон суралцсан бүх хичээлийн дүнг хамгийн сайн үнэлгээ авснаас нь эхлэн буурсан хэлбэрээр тодорхойлно. Сонгон суралцах хичээлүүдээс зөвхөн тэдгээр дүнгийн үнэлгээг шаардсан багц цагийн хэмжээнд хүрэх хүртэл эцсийн дүн үнэлгээний тооцоонд оруулна. Үлдсэн хичээлүүдийг эцсийн дүн үнэлгээний тооцоонд оруулахгүй.
- (5) Оюутнуудад шалгалтын дүнг бичгээр танилцуулна. Түүнчлэн, оюутнууд өөрсдийн цахим хувийн хэрэг дэх дүнтэйгээ танилцаж болно.
- (6) Суралцагч шалгалтандаа амжилтгүй дүн үзүүлсэн бол түүнд шалгалтын дүн болон дахин шалгалт өгөх боломжийг танилцуулна. Мөн мэдэгдэлд давж заалдах эрхийг дурдана.
- (7) Голч дүн нь хичээлийн багц цагийн хэмжээний дагуу тооцон хувиргасан дүн байна.
- (8) Бакалаврын шалгалтын эцсийн дүнгийн үнэлгээнд хичээлийн дүнгийн үнэлгээ, Бакалаврын дипломын ажлын болон хамгаалалтын дүнгийн үнэлгээ орно.
- (9) Бакалаврын шалгалтыг тооцуулахын тулд тус бүрдээ багадаа 60% гүйцэтгэлийн хувьтай бүх хичээл, Бакалаврын дипломын ажил болон эцсийн хамгаалалтыг гүйцэтгэсэн байна.
- (10) Эцсийн дүнгийн үнэлгээг тооцохдоо зөвхөн эхний 2 аравтын бутархайг харгалзан үзнэ. Бусад бүх аравтын бутархайг бүхэлдэхгүйгээр хасна.
- (11) Бакалаврын шалгалтын дүнгийн үнэлгээний хэмжүүр дараах байдалтай байна:

Дундаж, 3.60 хүртэлх ба оруулаад	A
Дундаж 2.60, 3.59 хүртэлх ба оруулаад	B
Дундаж 1.60, 2.59 хүртэлх ба оруулаад	C
Дундаж 1.00, 1.59 хүртэлх ба оруулаад	D



Дундаж, 1.00-с доош	F
---------------------	---

- (12) Шалгалтын комисс ерөнхийдөө онц сайн сурлагын амжилтад "амжилттай тэнцсэн" гэсэн нийт үнэлгээ өгч болно.

## VI. Дахин шалгалт, Бакалаврын шалгалтад амжилтгүй дүн үзүүлэх

### §19. Дахин шалгалт

- (1) Шалгалтад "амжилтгүй" дүн үзүүлсэн бол дахин өгч болно. Дахин өгөх шалгалтыг дараагийн улиралд багтаан өгөх ёстой. Амжилттай дүн үзүүлсэн шалгалтыг дахин өгөх боломжгүй.
- (2) Зөвхөн суралцагчийн бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн амжилтгүй дүн үзүүлсэн шалгалтыг 2 дахь удаагаа дахин авч болно. Хүсэлтийг Сургалт ба оюутны асуудал хариуцсан албанд гаргана. 2 дахь удаагийн дахин шалгалтыг үндсэн шалгалтын дараагийн улиралд авна. Шалгагч багштай зөвшилцөн 2 дахь удаагийн дахин шалгалтыг амаар авч болно.
- (3) 2 дахь удаагийн дахин шалгалт аман шалгалт бол суралцагч зөвлөх багш санал болгож болно.
- (4) 2 дахь удаагийн дахин шалгалтыг 2 шалгагч багш дүгнэж үнэлнэ. Шалгагч багш нар дүнгийн үнэлгээн дээр санал зөрсөн тохиолдолд Шалгалтын комисс шалгагч багш нарын саналыг сонссоны дараа эцсийн дүнгийн үнэлгээг гаргана.
- (5) Бакалаврын дипломын ажил болон эцсийн хамгаалалтыг 2 дахь удаагаа давтан хийхгүй.
- (6) 2 дахь удаагаа дахин шалгалт өгөх хүсэлт гаргахаасаа өмнө суралцагч Хөтөлбөрийн зохицуулагчтай зөвлөлдөх шаардлагатай.

### §20. Бакалаврын шалгалтад амжилтгүй дүн үзүүлэх

- (1) Дараах тохиолдолд суралцагчийг Бакалаврын зэрэг олгох шалгалтад эргэлт буцалтгүйгээр амжилтгүй дүн үзүүлсэнд тооцно:
  - (a) 2 дахь удаагийн дахин шалгалтад "амжилтгүй" дүн үзүүлэх;
  - (b) Бакалаврын дипломын ажил эсвэл эцсийн хамгаалалтад "амжилтгүй" дүн үзүүлэх;
  - (c) Шалгалтын журам эсвэл Шалгалтын комиссын шийдвэрийн дагуу цаашид шалгалтад орох эрхгүй болох.
- (2) Хичээлийн шалгалтууд, Бакалаврын дипломын ажил, эцсийн хамгаалалтын аль нэгэнд амжилтгүй дүн үзүүлсэн суралцагчид албан ёсоор мэдэгдэнэ. Мэдэгдэлд гомдол гаргах эрхийг дурдана.

### §21. Шалгалтын материалтай танилцах

Хичээлийн шалгалтын дүнг танилцуулсан эсвэл Бакалаврын зэрэг олгох шалгалтыг авч дууссаны дараа хүсэлт гаргасан оюутнуудад бичгийн шалгалтын материал, үнэлгээ, аман шалгалтын тэмдэглэлтэй танилцах эрхийг олгоно. Хүсэлтийг хичээлийн шалгалтын сүүлд эсвэл Бакалаврын зэрэг олгох шалгалтыг авч дууссанаас хойш нэг жилийн дотор гаргана.

## **§22. Шийдвэртэй санал үл нийлэх санал, гомдол**

- (1) Шалгалтын журмыг үндэслэн гаргасан аливаа шийдвэртэй санал үл нийлж болно. Энэ тохиолдолд оюутанд шийдвэрийн талаар мэдэгдсэнээс хойш нэг сарын дотор Шалгалтын комисст бичгээр гомдол гаргана.
- (2) Шалгалтын комисс гомдлыг авч хэлэлцэн, шийдвэрлэх ба шийдвэрийг оюутанд даруй бичгээр мэдэгдэнэ. Мэдэгдэлд шийдвэрийн үндэслэл, шийдвэрийг давж заалдах эрхийг дурдана.

## **VII. Гэрчилгээ**

### **§23. Диплом**

- (1) Дипломд холбогдох дүнгийн үнэлгээ, багц цаг бүхий бүх үзэж судалсан хичээл, эцсийн хамгаалалтын сэдэв, дүнгийн үнэлгээ түүнчлэн Хэсэг В §18 (8)-(11)-н дагуу голч дүнг жагсаан бичнэ. Хэсэг В §11-т тодорхойлсны дагуу гаргасан амжилтыг диплом дээр гадны их, дээд сургуулиудын нэрсийн хамтаар бичнэ. Суралцагч сайн дураараа үзэж судалсан МГТИС-иас санал болгосон хичээлүүдийг мөн бичнэ.
- (2) Дипломыг сүүлийн шалгалтыг амжилттай өгснөөс хойш 4 долоо хоногийн дотор олгоно.
- (3) Кирилл Монгол, Англи хэл, уйгаржин Монгол бичгээр бичсэн диплом олгоно.
- (4) Дипломд Факультетийн декан, Шалгалтын комиссын дарга гарын үсэг зурж, сургуулийн тэмдгээр баталгаажуулна. Дипломын хавсралт буюу дүнгийн жагсаалтад суралцагчийн хамгийн сүүлийн шалгалт өгсөн өдрийг тэмдэглэн бичнэ.

### **§24. Бакалаврын зэргийн диплом**

- (1) Бүх шалгалтаа өгсний дараа суралцагчид Хэсэг В §23-р зүйлд тодорхойлсон дипломын хамтаар боловсролын зэрэг олгосныг нотлох Бакалаврын зэргийн дипломыг олгоно. Кирилл Монгол, Англи хэл, уйгаржин Монгол бичгээр бичин, Факультетийн декан, Шалгалтын комиссын дарга, МГТИС-ийн Захирал гарын үсэг зурж, сургуулийн тэмдгээр баталгаажуулсан диплом олгоно.
- (2) Боловсролын зэргийг зөвхөн суралцагч Бакалаврын зэргийн диплом авсны дараа ашиглах боломжтой.

### **§25. Дипломын дагалдах хавсралт**

- (1) Монгол–Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль нь Европын Холбооны Дипломын хавсралтын загвартай дүйцэхүйц Англи хэл дээр бичсэн Дипломын хавсралтыг олгоно.
- (2) Зэрэг олгох хөтөлбөрийн сүүлийн 4 хичээлийн жилийн бүх хичээлийн шалгалтын дүнгийн статистик тоо баримтыг хичээлийн шалгалтын дүнгийн хамтаар Дипломын хавсралтад бичнэ.

### **§26. Дипломны дүнгийн хавсралт**

Бүх оюутнууд хэдийд ч бүх сурлагын дүн, үнэлгээнийхээ тойм үнэлгээтэй танилцах боломжтой. Дүнгийн тодорхойлолтод хичээлийн нэр, шалгалтын өдөр, дүн, цуглуулсан багц цаг, голч дүнг дурдана. Дүнгийн тодорхойлолтыг Англи эсвэл Монгол хэл дээр бичсэн байна.

## **VIII. Шалгалтын журмыг зөрчих**

### **§27. Шалгалтад хууль бусаар орох**

- (1) Суралцагч шалгалтад орох эрхийн шаардлагыг хангаагүй тохиолдолд суралцагч шалгалтад орохын тулд хуурч мэхлэх санаа агуулаагүй гэсэн нөхцөлтэйгөөр шалгалтад амжилттай дүн үзүүлсэн тохиолдолд тэрхүү нөхцөл байдлыг засаж залруулсанд тооцно.
- (2) Хэрэв суралцагч санаатайгаар шалгалтад орох эрхийг хууль бусаар олж авсан бол хичээлийн болон Бакалаврын шалгалтыг хоёуланг нь "хүчингүй"-д тооцно. Шийдвэр гаргахаас өмнө суралцагчийн саналыг сонсоно. Хууль бусаар олж авсан диплом, Бакалаврын зэргийн гэрчилгээ, дипломын хавсралтыг Сургалт ба оюутны асуудал хариуцсан алба хураан авна.

### **§28. Шалгалтын үеэр хуулах, дүрэм зөрчих**

- (1) Шалгалт авах явцад суралцагч хуурч мэхлэх, хуурч мэхлэх оролдлого хийх эсвэл зөвшөөрснөөс бусад эх үүсвэр, материалыг ашигласан тохиолдолд тухайн суралцагчийг даруй шалгалтаас гаргах ба шалгалтад "тэнцээгүй"-д тооцно. Сонирхлын зөрчил үүссэн нөхцөлд Шалгалтын комисстой зөвшилцөн шийдвэр гаргана.
- (2) Шалгалт авах явцад санаатай саад учруулсан суралцагчдыг шалгагч эсвэл хянагч багш шалгалтаас гаргана. Шалгалтад "тэнцээгүй"-д тооцно.
- (3) Хэсэг В §6 (3)-р зүйлийн дагуу мэдэгдэл ирүүлэн, ирүүлсэн мэдэгдэл нь үнэн зөв биш илрэх болон ирүүлсэн ажил нь өөр зохиогчийн ажил болох, өөр зохиогчийн ажил дээр дахин ажиллах, өөр ажлыг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн өөрчлөх, ашигласан материалаа дурдахгүйгээр ирүүлэхийг мөн хуурч мэхэлсэнд тооцно.
- (4) Суралцагч (1)-(3)-р зүйлд тодорхойлсон зөрчлийг давтан үйлдсэн тохиолдолд Шалгалтын

комисс тухайн суралцагчийг МГТИС-иас хасах эсэхийг шийднэ.

- (5) (1)-(4)-р зүйлд дурдсан тохиолдолд суралцагчид даруй бичгээр мэдэгдэх ёстой. Мэдэгдэлд шийдвэрийн үндэслэл, шийдвэрт гомдол гаргах эрхийн талаар дурдана.
- (6) Шалгалтын үеэр хууль бус үйлдэл гаргасныг хичээлийн шалгалтыг авч дууссанаас хойш 5 жилийн дотор олж мэдсэн нөхцөлд шалгалтад "тэнцээгүй"-д тооцно. Энэ нь Бакалаврын шалгалтад нөлөөлбөл, мөн "тэнцээгүй"-д тооцно. Шийдвэр гаргасан өмнө суралцагчийн аман тайлбарыг сонсоно. Тухайн суралцагчийн боловсролын зэргийг хүчингүй болгон, үнэн зөв бус диплом, Бакалаврын зэргийн гэрчилгээ, Дипломын хавсралтыг Сургалт ба оюутны асуудал хариуцсан алба хураан авна.
- (7) Шалгалтын комисс үл зөвшөөрөх нөхцөлд авагдсан бусад бүх шалгалтын хүчинтэй байдал, үнэлгээтэй холбоотой асуудлыг шийдвэрлэнэ.

#### **IX. Хүчин төгөлдөр болох**

- (1) Шалгалтын журмыг Захирлын тушаалын дагуу 2017 оны 4-р сарын 5-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.
- (2) Эрдмийн зөвлөлийн шийдвэрийн дагуу Шалгалтын журамд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэнэ.

#### **Хэсэг С - Хавсралтууд**

**Хавсралт 1 – Хичээлийн гарын авлага Уул уурхайн боловсруулах инженер**

**Хавсралт 2 – Хичээлийн гарын авлага Хүрээлэн буй орчны инженер**

**Хавсралт 3 – Хичээлийн гарын авлага Механик инженер**

**Хавсралт 4 – Хичээлийн гарын авлага Үйлдвэрлэлийн эдийн засагч инженер**